

2013 ОНЫ 10 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2013 оны 11 дүгээр сарын 25

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2013 оны 10 дугаар сарын байдлаар даатгалын салбартүйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2013.10.01	Нэмэгдсэн	Хасагдсан	/тоогоор/
					2013.10.31
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	240			240
3	Даатгалын төлөөлөгч	3143	41 ¹	83 ²	3101
4	Даатгалын зуучлагч	19			19
5	Даатгалын хохирол үнэлэгч	11	1 ³		12
6	Актуарч	15			15
7	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16
8	Даатгалын зуучлагч компанийн салбар	36			36
9	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	6			6

¹Хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 239 дүгээр тушаалаар “Ард даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-ийн 16 иргэнд, Хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 258 дугаар тушаалаар “Монгол даатгал” ХХК-ийн 25 иргэнд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг тус тус олгосон байна

²Хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 238 дугаар тушаалаар “Тэнгэр даатгал” ХХК-ийн 12 иргэн, Хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 248 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-ийн 71 иргэний даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.

³Хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 367 дугаар тогтоолоор “Фэйр валуэшин” ХХК-д даатгалын хохиролүнэлэгч ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2013 оны 10 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

Ердийн даатгалын компаниудын хувьд :


Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2013.10.31 /сарын дүн/	2013.10.31 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	8 158 729 331,19	68 812 255 873,31

Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	1 381 635 524,14	12 242 222 891,65
Олгосон нийт нөхөн төлбөр	2 870 370 463,48	21 316 958 567,11
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	870 766 632,00	7 879 010 533,57
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	2 032,00	17 823,00
Давхар даатгалд төлсөн хураамж	1 003 265 349,62	17 777 252 751,05
Байгуулсан даатгалын гэрээний тоо	65 722,00	509 312,00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	34 936,00	248 252,00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	36 703,00	290 849,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	240 236 568 378,82	6,644,894,519,874,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	75 401 922,72	75 401 922,72

2013 оны 10 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 68812.3 сая өгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 12242.2 сая өгрөг, олгосон нөхөн төлбөр 21316.9 сая өгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 7879.0 сая өгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирлын харьцаа сарын байдлаар 35.2 хувь, өссөн дүнгээр 31.0 хувь болсон бөгөөд өмнөх сараас 12.3 пунктээр, өссөн дүнгээр 0.5 пунктээр тус тус өссөн байна.

Даатгагчийн хохирлын харьцаа

/хувиар/



Ердийн даатгалын компаниудын 2013 оны 10 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Мандал генерал даатгал” ХХК-ийн гэрээ байна. Хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөрийг “ Монгол даатгал” ХХК 75.4 сая төгрөгийг олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2013.10.31 /сарын дүн/	2013.10.31 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	20 875 695,00	704 072 640,00
Олгосон нийт нөхөн төлбөр	14 633 438,00	151 825 340,00
Давхар даатгалд төлсөн хураамж	837 078,00	36 813 558,00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	14	178
Хувь х үний хугацаат даатгалд		32
Байгууллагын хугацаат даатгалд		17
Өндөр хамгаалалттай ЭМД-д		2
Эмнэлгийн мөнгөний даатгалд	1	29
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	3	6
Тэтгэврийн даатгалд		4
Орон сууцны даатгалд	2	5
Хуримтлалын даатгалд		
Зээлдэгчийн амь насны даатгалд	8	28
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	22 000 000,00	22 000 000,00

Урт хугацааны даатгагч 2013 оны 10 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр/ 704.0 сая өгрөгийн даатгалын хураамжийн орлоготой, 151.8 сая өгрөгийг нөхөн төлбөрт олгосон байна. Даатгалын хохирлын харьцаа 21.6 хувьтай байгаа бөгөөд өмнөх сараас /сарын дүнгээр/ 1.5 пунктээр нэмэгдсэн байна.



Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	2013.10.31 /сарын дүн/	2013.10.31 /өссөн дүн/

Нийт орлого	20 110 150 617,23	70 715 163 315,07
Даатгалын зуучлагчийн орлого	311 346 180,22	738 742 201,19
Үүнээс: Сайн дурын даатгал	225 583 112,12	559 282 099,43
Албан журмын даатгал	85 763 068,10	167 764 775,80
Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	572 185 027,58	1 397 018 476,46
Зуучилсан даатгалын гэрээний тоо	11 405,00	23 939,00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	831 730 271 253,76	831 730 271 253,76

2013 оны 10 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын зуучлагч компаниуд 738.7 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон байна. Үүний 75.8 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Асимон брокерс” ХХК-ийн зуучилсан гэрээ даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр 831730.3 сая төгрөгийн үнэлгээтэй байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Пийс оф лайф” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Си эн эн икс” ХХК, “Төрийн банк” ХХК-иуд тус тус орлогог үй ажилласан байна.

“Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Изи инвестмент” ХХК, ХХК, “Нэйшнл эженси” ХХК, “Гэрэлт буян ундрах” ХХК, “Эс би ай эс” тус тус 10 дугаар сарын мэдээг тус тус ирүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	2013.10.31 /сарын дүн/	2013.10.31 /өссөн дүн/
Нийт орлого	48 485 321,55	336 327 084,56
Даатгалын хохирол үнэлгээний орлого	47 081 503,37	201 879 902,66
Үүнээс: Сайн дурын даатгал	9 371 090,73	64 877 159,28
Албан журмын даатгал	24 360 412,64	117 137 287,38
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	1 600,00	11 180,00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	100 030 942,00	363 389 830,00

2013 оны 10 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 201.9 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс 21.5 хувийг сайн дурын, 58.1 хувийг албан журмын даатгалын хохиролын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Юу энд эн” “Тэгш сонголт эстимэйт” ХХК, “Файн эстимэйт” ХХК-иуд 10 дугаар сарын мэдээг ирүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 364 дугаар тогтоолоор “Албан журмын даатгагчдын холбооны удирдах өвлөлийн гишүүнээр томилох тухай” шийдвэр гаргасан байна. Мөн өдрийн 365 дугаар тогтоолоор “Хорооны 2012 оны 393 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангаас хөн төлбөр олгох заавар”, Хорооны 366 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор “Гэрэлт буян ундрах” ХХК, Хорооны даргын 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор “Ренессанс групп” ХХК-иудын хувьцаа эзэмшигчдийн ҮТ эц, дүрмийн санд тус тус өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан байна.

Хорооны 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 412 дугаар тогтоолоор “Монголиан интэрнэшнл брокерс” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

Хорооны оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 410 дугаар тогтоолоор “Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийн журам”, 411 дүгээр тогтоолоор “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага” -ыг тус тус баталсан байна.

ДААТГАЛЫН ГАЗАР